



### **ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА, БАГШ, СУДЛААЧДАД ТАВИХ ШААРДЛАГА**

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь боловсролын хөгжлийн бодлого болон сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны эрэлт хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйлчилгээг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг сургалт арга зүйн төв байгууллага юм. “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль шинээр батлагдсанаар тус институтийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж байгаатай холбогдуулан тус байгууллагад багшийн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг, зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага, багш, судлаачидтай хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага гарч байна.

#### **Нэг. Байгууллагад тавих шаардлага:**

- Улсын бүртгэлтэй, бие даасан хуулийн этгээд байх
- Сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй байх
- Хүний нөөц, менежментийн чадавхтай байх
- Нийгмийн үүрэг, хариуцлагаа биелүүлдэг байх
- Гадаад, дотоодод мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн, тэдэнтэй хамтарч ажилладаг туршлагатай байх
- Байгууллагын зорилго, үйл ажиллагааны чиглэл нь БМДИ-ийн зорилго, үндсэн чиглэлтэй нийцсэн байх
- Сургалтын анги танхим, орчин бүрдсэн байх /тусгай орчин нөхцөл шаардах сургалт зохион байгуулах тохиолдолд/

#### *Бүрдүүлж ирүүлэх материал:*

1. Хамтран ажиллах албан хүсэлт
2. Улсын бүртгэлийн гэрчилгээ
3. Сургалт явуулах тусгай зөвшөөрөл
4. Байгууллагын танилцуулга
5. Байгууллагын дотоод журам
6. Байгууллагын ёс зүйн дүрэм
7. Сургалтын хөтөлбөр (24 цагийн)
8. Байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагааг харуулсан нотлох баримт
9. Хамтран ажиллаж байсан 3 ба түүнээс дээш байгууллагын тодорхойлох захидал
10. Байгууллагын багш, судлаач, ажилтны мэргэшсэн байдлыг нотлох баримт /боловсрол, мэргэжил, мэргэшсэн байдал, туршлага, ур чадвар, харилцаа, хандлага/
11. Байгууллагын ажилтны мэргэжил дээшлүүлсэн байдлын бүртгэл, судалгаа
12. Тусгай орчин нөхцөл шаардагдах сургалт зохион байгуулах байгууллагын хувьд сургалтын анги танхимын тухай мэдээлэл /нийтээр болон бүлгээр сургалт зохион байгуулах анги танхим, сорил туршилт, мэргэжлийн камер, дуу бичлэг хийх техник хэрэгсэл, тоног төхөөрөмж бүхий лаборатори, кабинет зэргийн тоо, хэмжээ, багтаамж/
13. Байгууллагын үйл ажиллагааны талаар эрх бүхий байгууллагаас хийсэн үнэлгээ, дүгнэлт /энэ шаардлага төрийн байгууллагад хамаарахгүй/

14. Сүүлийн 3 жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн товч танилцуулга /нийгмийн даатгал, татвар төлсөн баримт г.м, энэ шаардлага төрийн байгууллагад хамаарахгүй./

**Хоёр. Багш, судлаачдад тавих шаардлага:**

- Боловсрол судлал, СХУ, сэтгэл судлал, боловсролын удирдлага, мэргэжлийн дидактик, менежмент, хувь хүний хөгжил, судалгааны арга зүй, нийгмийн ажил, хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр мэргэжил эзэмшсэн, магистр ба түүнээс дээш боловсролын зэрэг, цолтой байх
- Их, дээд сургуульд багш, удирдах ажилтан, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагад багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан, арга зүйч, мэргэжилтнээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай
- Сургалтын хөтөлбөр, стандарт, сургалтын арга зүй, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, үнэлгээ, багш боловсролын чиглэлээр сургалт судалгааны ажлын туршлагатай
- Насанд хүрэгчдийн сургалтын арга зүй эзэмшсэн, сургалт зохион байгуулах туршлагатай байх
- Хүнтэй ажиллах арга барил, харилцааны соёл эзэмшсэн, зөв төлөвшилтэй, ажил гүйцэтгэх чадвартай, хариуцлагатай ханддаг байх
- Мэдээлэл харилцааны технологи ашигладаг, гадаад хэлээр мэдээлэл олж ашиглах чадвартай, судалгааны арга зүй эзэмшсэн, төлөвлөх, зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах чадвартай, бичиж найруулах чадвар өндөртэй байх
- Багаар хамтарч ажилладаг, хувийн үзэл бодлоо тулгадаггүй, ойлголцлыг эрхэмлэдэг байх
- Хувийн бизнес, үйл ажиллагаа, шашин, улс төрийн талаар болон бусад сурталчилгаа хийдэггүй, тавигдсан шаардлагын дагуу ажилладаг байх
- БМДИ-ийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтний ажлын байрны жишиг тодорхойлолтыг баримтлан ажилладаг байх

*Бүрдүүлж ирүүлэх материал:*

1. Хамтран ажиллах хүсэлт
2. Хариуцлагатай ажилтны анкет, CV
3. Мэргэжил эзэмшсэн, мэргэшсэн байдлыг нотлох баримт /их дээд сургуулийн диплом, боловсролын болон эрдмийн зэрэг цол хамгаалсан диплом, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан сертификат/
4. Сургалтын хөтөлбөр (24 цагийн)
5. Насанд хүрэгчдэд зохион байгуулсан сургалт, бие дааж болон хамтран гүйцэтгэсэн судалгааны ажлын танилцуулга, үр дүнг нотлох баримт /хэвлэлийн мэдээ, тайлан... /
6. Бүтээлийн жагсаалт
7. Хамтран ажиллаж байсан 2-3 удирдах ажилтан, мэргэжилтний тодорхойлох захидал
8. Тус байгууллагатай хамтран ажиллаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөх өгөх төсөөлөл, төлөвлөгөө